

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 12-р сарын 20 өдөр

Дугаар №03/21

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2021 оны 12-р сарын 20-ны өдрийн 15.20 цагт Монноос ХК-ийн байранд болсон.

ХЭХурлын дарга: Б.Цолмон

Тооллогын комиссын дарга: Э.Тогосмаа

Тооллогын комиссын гишүүн: Д.Даваасүрэн /Монноос ХК Ерөнхий менежер/
С.Дэнсмаа нар ажилласан.

Хуралд оролцсон: Монноос ХК-ийн хувьцаа эзэмшигчид:

1. Д.Гиваапил- 69732ш
2. Адам Холдворсын итгэмжлэлээр П.Оюунбаяр-69824ш
3. С.Алимаа-14443ш
4. Марал импекс ХХК-ийн итгэмжлэлээр Л.Нямжав-69824ш
5. Шандас импекс ХХК-ийн итгэмжлэлээр М.Гөлгөө-20556ш
6. А.Жигүүр-20176ш
7. А.Дүүрэнбилэг-26377ш
8. М.Амаржаргал-7874ш
9. Аргай бест ҮЦК-58ш
10. Ж.Энхтунгалаг-17ш

Монноос ХК-ийн нийтэд гаргасан 350877ш хувьцаанаас 298881ш хувьцаа эзэмшигч буюу 85,2%-ийн саналын эрх бүхий оролцогч оролцсноор хурлыг хүчинтэй гэж үзээд хурлыг 15 цаг 20 минутад эхлүүлж, 1 цаг 20 минутад багтаан явуулахаар тогтоов.

Хурлын дэгийг ХЭХурлын дарга Б.Цолмон танилцуулж, хуралд оролцогчдын 100%-ийн саналаар батлав.

Хурлаар хэлэлцсэн асуудал:

1. Хувьцааг нэгтгэх асуудал
2. Хувьцааг нэгтгэх журам төсөл
3. Хувьцааг нэгтгэх өөрчлөлтйг компанийн дүрэмд тусгах

4. Хурлаар хэлэлцсэн нь:

1. Монноос ХК-ийн Хувьцааг нэгтгэх асуудлаар Х.Эрдэнэбаяр танилцуулга хийв.

Х. Эрдэнэбаяр /ГЗ/- Монноос компани 1991 онд хувьчлагдаж, Монноос хувьцаат компани болсон. Хувьчлагдсаны дараа компанийн үйл ажиллагаа хумигдсаар 2000 онд тус компани 209 ажилчидтай, 2131,1 тонн ноос бэлтгэн угааж, үйлдвэрлэлийн хүчин чадлынхаа дөнгөж 18,3% - ийг ашиглаж байсан.

Үйл ажиллагаа зогсонги байдалд орж, үйлдвэрлэл хүндрэл, бэрхшээлтэй байсан боловч үйл ажиллагаагаа шинэчилж, үйлдвэрлэлийг хэвийн ажилд оруулах зорилгоор ихээхэн хэмжээний зээл авч шаргуу ажилласаны үр дүнд 2003-2004 оны үеэс үйлдвэр тодорхой хэмжээнд ажиллаж эхэлсэн боловч багагүй хэмжээний өр хуримтлагдаж, түүнийг барагдуулах хэмжээний орлого олж

“МОННООС”

ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

чадахгүй хэвээр байлаа.

2002 он гэхэд дотоодын хонины ноос боловсруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хивс, эсгий гутал, нэхмэл, сүлжмэлийн ихэнх үйлдвэрүүд хаагдаж, гадаад зах зээлд Монгол хонины бүдүүн ширхэгт ноосны хэрэгцээ, худалдан авалт буурсанаар, борлуулалтын орлого огцом буурч, эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр дутагдсанаар үйлдвэрлэлийн үйл ажиллагаа бүрэн зогссон. Компани нь 2002 оноос эхлэн одоог хүртэлх хугацаанд компанийн байр, талбайг түрээсэлж, түрээсийн үйлчилгээгээр борлуулалтын орлого бүрдүүлж байсан. Гэхдээ үйлдвэрлэлийн талбайн багахан хэсгийг түрээслэдэг учраас олох орлого бага, тогтмол гардаг зардал хэвээр байсан учраас жил бүр алдагдлын хэмжээ өсөн нэмэгдэж ирсэн учраас 2,1 тэрбум ₮-ийн хуримтлагдсан алдагдалтай байна.

2019 оны үед үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжид их засвар хийж, бусад байгууллагын бэлтгэсэн ноос, ноолуурыг угаах үйлчилгээ үзүүлж эхэлсэн боловч, олон жил зогссон, засвар үйлчилгээ хийгээгүй цэвэрлэх байгууламж доголдож, бохир усны хаягдалд байх хорт бодисын агууламж байвал зохих хэмжээнээс ихэссэн учраас хяналт шалгалтын байгууллагын дүгнэлтээр ноос ноолуур угаах ажиллагааг зогсоосон болно. Мөн түүнчлэн цэвэрлэх байгууламжийг дахин засварлахад олон тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай болсны зэрэгцээ, Монгол улсын засгийн газрын өгсөн чиглэлийн дагуу Нийслэлийн Байгал орчны газраас Улаанбаатар хотод ноос угаах үйлдвэрлэл явуулахыг хязгаарлах болсон тул угаах үйлдвэрлэлийн 2 шугамыг Говь-Алтай, Өвөрхангай аймагт 2 салгаж шилжүүлэх, хуримтлагдсан өрийг төлж барагдуулах зэрэгт шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр гаргахын тулд компанийн үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах саналаа ТУЗ-өөр дэмжүүлээд улмаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас компанийн үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах замаар хөрөнгөө эргэлтэд оруулах шийдвэр гаргасан байгаа.

Одоогийн байдлаар манай компанид ээлжийн харуул-3, үйлдвэрийн дарга 1, захиргааны 2 ажилтан нийт 6 ажилчинтай байна.

Хувьцааг нэгтгэх зорилго, шаардлага нөхцөл:

Нэгэнт үндсэн үйл ажиллагаа орон нутагт шилжиж байгаа тул УБ хотод оффис, үйлдвэрийн барилга байгууламж шаардлагагүй болсон. Барилга байгууламжуудыг түрээслэн бага хэмжээний орлого олж байсан боловч 2019 оноос эхлэн цар тахлын нөлөөгөөр түрээслэгч нар гэрээгээ цуцалснаар орлого хумигдаж, компани нь зөвхөн зардлын зарим хэсгийг л нөхөх хэмжээнд ажиллаж, харуул хамгаалалт, үл хөдлөх хөрөнгө, газрын татвар эрчим хүч дулааны зардлыг харилцагч байгууллага, эзэлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхэд хүрээд байна. Ийм учраас Улаанбаатар хот дах үл хөдлөх хөрөнгөө худалдан борлуулж, борлуулалтын орлогоор өр төлбөрөө барагдуулаад, Говь-Алтай, Өвөрхангай аймгуудад компанийн үйл ажиллагааг шилжүүлэх нь зүйтэй гэж ТУЗ үзэж байгаа болно. Энэхүү бодит нөхцөл байдлыг манай хувьцаа эзэмшигчид ойлгож асуудлыг нааштай шийдвэрлэсэнд гүйцэтгэх удирдлагын зүгээс талархалтай байгаа.

СЗХ-оос манай ээлжит бус хурлын шийдвэрийг хянаад, компанийн үл хөдлөх хөрөнгийг худалдсанаар жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зөрчигдөх эрсдэл үүсч болзошгүй гэж сэрэмжлэн, манай ХЭХ-ын шийдвэрт зөвшөөрөл олгоогүй байна.

Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах гол арга зам нь тэдний хувьцааг шударга үнээр худалдан авах явдал бөгөөд тэдний хувьцааг худалдан авах эрх зүйн үндэслэл үүсэх нь Хувьцааг нэгтгэх арга зам юм.

100 шахам жилийн түүхтэй Монгол улсын ууган үйлдвэрийн нэг болох Монноос компанийг ХХК болгох нь зохимжгүй, ноосны салбарын үйл ажиллагаа сэргэх үед ХК хэвээр үйл ажиллагааг сэргээн, ноос, ноолуур боловсруулах чиглэлээр үйлдвэрлэл явуулах боломжтой болно гэдэгт итгэлтэй байгаа учраас ХК хэвээр үлдэх замыг сонгож байгаа болно. Ийм учраас, нэгдүгээрт жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааг шударга үнээр худалдан авах эрх зүйн үндсийг бүрдүүлэх, нөгөө талаас компанийн ХК гэсэн статусыг хадгалан үлдэх зорилгоор хувьцааг нэгтгэхээр шийдвэрлэсэн болно. Тэгээд ч 20-50 ширхэг хувьцаатай 1600 орчим хувьцаа эзэмшигчид нь хувьцаагаар гэрчлэгдсэн эрхээ ямар нэг байдлаар хэрэгжүүлэлгүй удсан учраас тэдний хувьцааны үнийг мөнгөн хэлбэрт шилжүүлэн үнэт цаасны хадгаламжийн байгууллагад шилжүүлэн хадгалуулснаар тэд хүссэн үедээ мөнгөө авах боломжийг хангаж өгөх болно.

ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хувьцааны бутархай үлдэгдлийг Компанийн тухай хууль болон Хорооны журамд заасны дагуу хувьцааны сүүлийн 6 сарын дундаж ханшийн талаарх мэдээлэлд үндэслэн ТУЗ-өөс тогтоосон үнэ болох 2827 төгрөгөөр худалдан авахад нийтдээ 106 сая орчим төгрөг зарцуулагдахаар тооцоо гарч байгаа. Энэ мөнгийг ҮЦТХТөвд байршуулах замаар жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангах болно.

2. Хувьцаанг нэгтгэх журамын төслийг зөвлөх Аюуш танилцуулга хийв.

Б.Аюуш/ зөвлөх/- Сая Эрдэнбаяр захирал Хувьцаа нэгтгэх журмын төслөөс танилцууллаа. Би нэмж тайлбар өгье. Хувьцааг нэгтгэх шаардлага яагаад үүсэн бэ гэвэл Улаанбаатар хотод ноос угаах үйлдвэрийг ажиллуулахгүй гээд Хотын засаг даргын захирамж гарсан. Иймээс ноос угаах үйлдвэрүүд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон. Иймээс ноос угаах үйлдвэрээ 2 аймагт хэсэглэн шилжүүлж, үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн байгаа. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон учраас энд байгаа үл хөдлөх хөрөнгөө худалдаад хуримтлагдсан алдагдлаа нөхнө, хуримтлагдсан ер төлбөрөө нөхнө, 2 аймагт үйлдвэрээ шинээр барьж байгуулна, тоног төхөөрөмжөө суурилуулна, шийлжүүлнэ. Эдгээр зардлуудыг нөхөх зорилго тавигдсан. Тэгээд 8-р сард хуралдсан хурлаар үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах зөвшөөрөл авагдсан. Үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах ажиллагааг хэрэгжүүлэхэд Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөл хэрэгтэй болсон. Санхүүгийн зохицуулах хороонд хандснаар энэ үйл ажиллагааг явуулснаар жижиг хувьцаа эзэмшигчдэд хохирол учирч болох юм, тэд нар эрсдэл хүлээж болох юм гэсний үндсэн дээр жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахыг үүрэг болгосон. Жижиг хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг хамгаална гэхээр хувьцааг нь эргүүлэн худалдан авах арга зам үлдэж байгаа.

Энд 2 арга зам байна. Нэг дэх нь ХХК болгох, Хоёр дахь нь Хувьцааг нэгтгэх. ХХК болгох аргыг сонгохгүй гэдгийг сая ГЗахирал тайлбартаа дурдсан байгаа. Бараг 100-аад жилийн түүхтэй ноос угаах үйлдвэр. 12 жилийн дараа 100 жилийн ойгоо тэмдэглэх үйлдвэрийг ХХК болгоно гэдэг бол тохиромжтой биш юм. Хөрөнгийн зах зээл урьд жилүүдээс сэргэх хандлагатай болж байгаа. Гэхдээ угаах чиглэлээр Улаанбаатар хотод үйл ажиллагааг явуулах боломжгүй болсон. Ер нь ноос ноолуурын чиглэлээр үйлдвэр явуулах болоход 100-аад жилийн түүхтэй компанийг ХХК болгоход тохиромжгүй гэж үзсэн. Тэгэхээр нэг арга үлдсэн нь Хувьцааг нэгтгэх арга. Хувьцааг нэгтгэх арга нь 50ш хувьцааг нэг хувьцаа болгон нэгтгэх аргыг яагаад сонгосон вэ гэвэл нийт хувьцаа эзэмшигчдийн тоо 1831 байгаа. Түүнээс 1600 гаруй хувьцаа эзэмшигчид нь 50 хүртэлх хувьцаатай хүмүүс. Хувьцаатай эсэхээ мэддэг эсэх эргэлзээтэй байгаа. Гэхдээ анх 70ш хувьцааг өмч хувьчлалын үед давуу эрхээр үйлдвэрийн ажилчид эзэмшсэн байгаа. 70ш хувьцаатай үйлдвэрийн ажилчид одоо ч гэсэн үйлдвэртэйгээ ямар нэгэн холбоотой байдаг учраас тэдгээрийг хувьцаа эзэмшигчээр үлдээх нь зүйтэй юмаа гэж үзсэн. Тэгээд 50ш хувьцааг 1ш хувьцаа болгон хөрвүүлэх замаар Хувьцааг нэгтгэх арга замыг сонгосон байгаа. Хувьцааг нэгтгэх тооцоог бүртгэх өдрөөр тасалбар болгож, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс бүртгэлийг гаргуулж авсан байгаа. Энэ бүртгэлээр 1600 гаруй хувьцаа эзэмшигчид 50ш-ээс доош хувьцааг эзэмшигчид байгаа. Эдгээр хүмүүсийн хувьцааны бутархай үлдэгдлийг сүүлийн 6 сарын дундаж ханшинд үндэслэн ТУЗ-ийн тогтоосон үнээр эргүүлэн худалдан авч болно гэж Компанийн тухай хуулинд заасан байгаа. Түүний дагуу сүүлийн сарын дундаж ханшаар биш 6 сарын хамгийн дээд ханшийг 10 хувиар өсгөсөн дүнгээр буюу 2827 төгрөгөөр худалдан авахаар ТУЗөвлөл шийдвэрлэсэн. Энэ бол хувьцаа эзэмшигчдийн хувьд хамгийн тааламжтай шийдэл юм. Хувьцаа эзэмшигчдийн нэг бүрээр тооцоо хийсэн байгаа. Тэр нэгдсэн тооцоог тараах материал хавсаргаагүй байгаа. Тооцоогоор 173 хувьцаа эзэмшигчид компанид үлдэнэ. 50ш хувьцааг 1ш хувьцаа болгож нэгтгэхэд 6267ш хувьцаатай болно. Үлдсэн

“МОННООС”

ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

173ш эзэмшигчдийн хувьцааны бутархай үлдэгдэл дээр 3532ш хувьцаа байгаа. 1658 хувьцаа эзэмшигчид 50 хүрэхгүй хувьцаатай учраас тэдний хувьцааны 33985ш үлдэгдлийг ТУЗ-ийн тогтоосон үнээр худалдаж авна. Нийтдээ 37527ш хувьцааг эргүүлэн худалдаж авна. Ингэхэд 106сая.төгрөгний хөрөнгөний зардал гарах юм. Энэ журмын дагуу 6267ш хувьцаа эзэмшигчидтэй болно. Энэ тооцоонд дээр үндэслэн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд 37527ш хувьцааны 106сая.төгрөгийг шилжүүлнэ. Ингэснээр хувьцааг нэгтгэх үйл ажиллагаа дуусгавар болно. Хувьцааг нэгтгэсэн учраас Компанийн дүрэмд өөрчлөлт орно. Дүрмийн өөрчлөлтийг Эрдэнэбаяр захирал танилцуулна. Компанийн дүрмийн өөрчлөлтөнд 6267ш хувьцаа болж өөрчлөгдөх юм. Хувьцааны үнийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд шилжүүлж байршуулна. Жижиг хувьцаа эзэмшигчид компанийн хувьцааны үнийг өөрсдөө хүссэн үедээ бэлэн мөнгө авах боломж нээгдэх юм. Ингээд хувьцаа нэгтгэх үйл ажиллагаа дуусгавар болно. Тэрнээс гадна өнгөрсөн 8-р сард Компанийн үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах шийдвэр гарсан. Энэ шийдвэр бол компанийн хуулинд заасны дагуу их хэмжээний хэлцэл байгаа. Их хэмжээний хэлцэл хийсэн тохиолдолд Хувьцаа эзэмшигчид хувьцаагаа компанид эргүүлэн худалдах эрх үүсдэг. 1600 гаруй хувьцаа эзэмшигчид хувьцааг шударга үнэнээр худалдан авахаар тогтоосон учраас эдгээр хүмүүс ийм эрх эдлэх шаардлага байхгүй. Үлдсэн 173 хувьцаа эзэмшигчид энэ эрхийг хэрэгжүүлнэ. Энэ эрхийг хэрэгжүүлэхдээ Компанийн тухай хуулинд яаж хэрэгжүүлэхийг заасан байгаа. Энэ ХЭХ-ын материалыг ажлын 3 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид өгнө. СЗХ, Хөрөнгийн бирж энэ хурлын шийдвэрийг хуульд нийцүүлэн гаргасан гэсэн шийдвэрийн дараа энэ эрхийг хэрэгжүүлэх эрхзүйн үндэслэл үүснэ.Тэгэхээр ХЭХ-ын журмын дагуу 173 хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэнэ. Хувьцааг эргүүлэн худалдах эрх үүссэн гэдэг мэдээллийг хүргэнэ. 173 хувьцаа эзэмшигчид хувьцааг эргүүлэн худалдах мэдэгдлээ ирүүлж болно.Хувьцааны үнэ болох 2827төгрөгөөр хувьцааг эргүүлэн худалдаж авах үйл ажиллагааг ТУЗ-өөс зохион байгуулж хэрэгжүүлэх болно. ТУЗөвлөлөөс энэ ажиллагааг зохион байгуулах үүргийг ГЗахиралд өгсөн байгаа.

3. Хувьцааг нэгтгэсэн өөрчлөлтийг Компанийн дүрэмд оруулах асуудлыг танилцуулав.

Х.Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/-Компанийн хувьцааг нэгтгэх шийдвэр гарвал компанийн дүрэмд доорх өөрчлөлт орно.

1. Компанийн дүрмийн 3.1-т заасны дагуу компанийн зарласан хувьцааны нэг бүрийн үнэ 100төгрөг, 350877ш энгийн хувьцаанаас бүрдэнэ гэсэн заалт өөрчлөгдөж, 3.1-т компанийн хувьцааны нэг бүрийн үнэ 5000 төгрөгний нэрлэсэн үнэтэй 6267ш энгийн хувьцаанаас бүрдэнэ гэсэн заалт өөрчлөгдөнө.
2. Компанийн дүрмийн 3.2-т заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн эзэмшсэн буюу эргэлтэнд гаргасан нэрлэсэн хувьцааны үнийн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нэг бүрийн 5000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 6267ш хувьцаатай байна гэсэн өөрчлөлт орно. Ийм 2 өөрчлөлт компанийн дүрэмд орно.

Та бүхний саналын хуудсаар өгсөн саналаар энэ нь дэмжигдвэл Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэх үйл ажиллагаа явагдана.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой санал, шүүмжлэл

Ж.Энхтунгалаг /Хувьцаа эзэмшигч/- Би компанийн 17ш хувьцаатай. 50ш доош хувьцаатай хувьцаа эзэмшигчдэд орж байгаа юм байна. Хувьцааны үнийн зөрүүг худалдаж аваад хувьцаа эзэмшигчээр үлдэж болох уу?

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Б.Аюуш /Зөвлөх/ -Болно. Тэгэхээр 50ш хүртэл хувьцааны зөрүү 33ш хувьцааг 2827 төгрөгөөр үржүүлээд 1ш хувьцаатай болоод хувьцаа эзэмшигч хэвээр үлдэж болно.

Ж.Энхтунгалаг /хувьцаа эзэмшигч/- Би брокерын пүүстээ хандаад, танай хувьцаанаас худалдан авах захиалга өгөөд, мөнгөө байршуулах юм уу

Б.Аюуш /Зөвлөх/-Брокерын пүүст биш компанидаа 33ш хувьцааны үнийг шилжүүлээд, 1ш хувьцаатай болно.Тэгсэн тохиолдолд дүрэмд орсон хувьцааны тоо өөрчлөгдөж, 6268ш хувьцаатай болно.

А.Жигүүр /хувьцаа эзэмшигч/-Би компанийн бага хэмжээний эзэмшигчийн төлөөллийн нэг. Өөрөө бас Дүүрэнбилэг хувьцаа эзэмшигчдийг төлөөлж ирсэн. Монноос ХК нь 1992- 2002 он хүртэл монголын томоохон компанийн нэг, баялаг бүтээгчдийн нэг болж явсаар ирсэн. Өнөөгийн нөхцөлд үйл ажиллагаа нь ч зогсонги байдалтай, төлбөр мөнгөний өрөнд ч орсон, ийм байдалтай байгаад харамсалтай байна. Энэ хурлын талаар саяхан хэдхэн хоногийн өмнө мэдлээ. Уг нь дүрэм ёсоороо брокерын пүүс рүү материал нь очих ёстой. Хурал хуралдуулах шийдвэр гарсаны дараа 10 хоногийн дотор багтаж очих ёстой байсан. Надад төслийн журам ирсэн, төслийн журманд үнийн дүн, тоо баримт байхгүй байсан. Та бүхэн цаашдаа анхаарч ажиллах байх. Миний ойлгохгүй нэг зүйл бол хувьцаа нэгтгэх шалтгаан нь 1600гаруй хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хөндөгдөж байна. Та бүхний хэлж байгаагаар төлбөр мөнгөний асуудалд орсон, үйл ажиллагаа явахгүй байгаа, ноосны үйлдвэрийг УБ хотод явуулж болохгүй шалтгааныг хэлж байна. Үл хөдлөх хөрөнгийг худалдах зорилгоор хувьцаагаа нэгтгэх гээд байгаа харагдаж байна. Зөвхөн үл хөдлөх хөрөнгөө худалдахын тулд хувьцаа нэгтгэж, 1600 гаруй хүний эрх ашгийг хөндөх нь зөв үү, буруу юу. Үл хөдлөх хөрөнгийг зарлаа гэж бодоход компани маань 2,1тэрбум.төгрөгний алдагдалтай. Олсон мөнгийн ихэнх нь өр төлбөр барагдуулахад явах гэж байна. Үлдсэн 7-10тэрбум төгрөгөө яаж зарцуулах гээд байна. Энэ дээр ямар бизнес төлөвлөгөө алга байна. Одоогийн ярьж байгаагаар 2 аймаг руу үйлдвэрлэлээ шилжүүлнэ гэж ярьж байна. Бодитоор энэ мөнгийг яаж зарцуулах гээд байгаа нь, үнэхээр ноосны үйлдвэр үл хөдлөх хөрөнгөө борлуулчихаад, цаашид үйл ажиллагаа явуулахгүй зогсчих вий. Бизнес төлөвлөгөөгөө тодорхой хэмжээнд гаргаад, энэ компани нь 5-10 жилийн дараа ийм болно, орон нутагт очсноор ийм болно гэдгийг тодорхой хэлэх хэрэгтэй. Надад хөрөнгөө борлуулаад дуусах юм шиг харагдаад байна. Үүнийг анхаарна биз. Компанийн санхүүгийн чадвар нь 2,1тэрбум.төгрөгийн алдагдалтай болсон байна. Өглөг нь хэдтэй байгаа вэ?

Х.Эрдэнбаяр /ГЗахирал/-16 тэрбум төгрөг байгаа.

А.Жигүүр /хувьцаа эзэмшигч/-худалдсан мөнгөөрөө өр төлбөрөө төлөөд цаашид яах вэ? Дээр нь 106сая.төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд яаж олгох вэ? Компанийн тухай хуулийн 52.1-т зааснаар Компани өөрийн хувьцааг эргүүлэн авахын тулд төлбөрийн чадвартай байх хэрэгтэй гэж байгаа. Алдагдалгүй байх хэрэгтэй гэсэн байгаа. Тэгж байж компани хувьцааг эргүүлэн худалдан вах талаар ярих болохоос имий өртэй байгаа компани хувьцаагаа эргүүлэн худалдаж авна гэдэг нь Компанийн тухай хуультайгаа зөрчилдөж байна. Өнөөдрийн хурал хүчин төгөлдөр хурал уу, дахиж явах уу?

Б.Аюуш /зөвлөх/-Хүчин төгөлдөр хурал.

А.Жигүүр /хувьцаа эзэмшигч/-1600 гаруй хувьцаа эзэмшигчдийг хасчихаад, үл хөдлөх хөрөнгө борлогдохгүй байвал яах вэ? Энэ хэмжээний том барилгыг худалдаж авах хүн олдох уу, үгүй юу?

“МОННООС”

ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Борлогдохгүй бол 1600 гаруй хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хөндөөд, дээр нь 106 сая. төгрөгийн алдагдал хүлээвэл яах вэ? Компанийн дүрэмд өөрчлөлтөн дээр 173 хувьцаа эзэмшигчдийн нэг хувьцааны үнэ-5000 төгрөг болно гэж байхад хувьцаа нэгтгэх 2827 төгрөгөөр бусдаас худалдаж авна гэдэг нь зөв үү, буруу юу? Хувьцаа нэгтгэх тал дээр эсрэг байр суурьтай байна.

Б.Аюуш /Зөвлөх/- Хувьцаа нэгтгэх шалтгаан бол үл хөдлөх хөрөнгө худалдах нь гарцаагүй болсон. УБ-т ноос угаах үйлдвэр явуулахыг хориглосон. Тэгэхээр УБ хотод үйл ажиллагаа явуулахгүй болсноос хөдөө орон нутагт шилжүүлэхээс өөр гарц байхгүй. Үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах нь энэ компанийн ТУЗ, Гүйцэтгэх удирдлагаас үл хамаарсан шийдвэр гарсан. Үл хөдлөх хөрөнгөө худалдан борлогдох талаар ГЗахирал тайлбар өгөх байх. Хувьцаа нэгтгэх үйл ажиллагаа СЗХорооны шаардлагаар хийгдэж байгаа. Үл хөдлөх хөрөнгөө худалдаад орон нутагт үйл ажиллагааг шилжүүлнэ гэсэн байр суурьтай байгаа. СЗХороо жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдаж ав гэсэн шаардлага тавигдсан. Хувьцааг худалдаж авах эрхзүйн үндэс бол 2 тохиолдолд үүснэ. 1-т ХХК болох, 2-т Хувьцаа нэгтгэх. Тийм учраас ТУЗөвлөл ХХК болохыг зохистой биш гэж үзсэн. 100-аад жилийн түүхтэй компани хөрөнгийн зах зээл сэргэж байгаа, УБ-т ноос угаах үйлдвэр явуулахгүй нь ойлгомжтой, ноос ноолуурын чиглэлээр Монгол улсын нэрийг дэлхийд гаргах үндсэн чиглэл учраас ноосны чиглэлээр цаашид үйл ажиллагаа явуулна. Тэгэхээр ХХК болохгүй гэсэн байр суурьтай байгаа учраас хувьцаа нэгтгэх аргам замыг сонгосон. Жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааг шударга үнэнээр худалдаж авах эрхзүйн үндэслэл бий болж байна. Хувьцаа нэгтгэхийн эсрэг байр суурьтай болно. Үл хөдлөх хөрөнгийг худалдах хэлцэл хэдэн төгрөгөөр хийгдэж байгаа вэ?

Х.Эрдэнэбаяр/ГЗ/- ХЭХурлын шийдвэрээр үл хөдлөх хөрөнгө худалдах доод үнийг 35тэрбум.төгрөгөөр тогтоосон байгаа. Худалдах хэлцэл явагдаж байгаа.

Б.Аюуш /зөвлөх/- Үл хөдлөх хөрөнгөө худалдана, өр төлбөрөө барагдуулна, үлдсэн хөрөнгөөрөө 2 аймагт үйлдвэр барьж байгуулна, 2 аймагт 2 угаах шугамыг суурилуулах ажил явагдана. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хийж байгаа. Хийж дуусаагүй учраас танилцуулаагүй байгаа байх. Хувьцаа эзэмшигчдийн эргүүлэн худалдаж авах тооцоог СЗХорооноос ТУЗ ХЭХурал хуралдуулах шийдвэр гаргаснаас хойш 4 хоногийн дараа бүртгэх өдрийг тогтоодог журам бараг 20 жилийн турш явж ирснийг СЗХороо хурал хуралдахаас 15 хоногийн өмнө гээд өөрчилсөн. Тэгэхээр 15 хоногийн өмнө эдгээр тооцоонуудыг хийх үндэслэл болсон Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хүлээж авсан гэсэн үг. Тэгэхээр 15 хоногийн өмнө энэ материалыг хүлээж аваад, та нарт өгөх материал бэлэн болсон гэсэн үг. Хувьцаа нэгтгэх асуудал бол ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зүгээс хийгдэж байгаа асуудал биш, СЗХорооны шаардлагаар хийгдэж байгаа ажил.

А.Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- СЗХороо нь санхүүгийн байгууллагад шийдвэр өгдөг байгууллага биш хяналтын байгууллага. СЗХорооны шийдвэр нь өмнөх ХЭХурлын шийдвэр хүчин төгөлдөр бус байна. Яагаад гэвэл энэ нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хөндөж байна. Хурлын шийдвэрийг зөвшөөрөхгүй гэсэн болохоос хувьцаагаа нэгтгэ, нэгтгэхгүй бол болохгүй гэсэн шаардлага өгдөг байгууллага биш. СЗХороо хууль, дүрмийн дагуу явуулахыг шаарддаг байгууллага биш аливаа нэг компанийн үйл ажиллагаанд ороод, хувьцаагаа нэгтгэх гм компанийн дотоод үйл ажиллагаанд ордоггүй.

Б.Аюуш /Зөвлөх/- Тийм биш. Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хөндөгдөж байгаа учраас та нар хувьцааг шударга үнээр худалдаж аваа гэсэн. Өмнөх ХЭХурал хүчин төгөлдөр болсон, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хөндөгдөж байна.

“МОННООС”

ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Борлогдохгүй бол 1600 гаруй хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хөндөөд, дээр нь 106 сая. төгрөгийн алдагдал хүлээвэл яах вэ? Компанийн дүрэмд өөрчлөлтөн дээр 173 хувьцаа эзэмшигчдийн нэг хувьцааны үнэ-5000 төгрөг болно гэж байхад хувьцаа нэгтгэх 2827 төгрөгөөр бусдаас худалдаж авна гэдэг нь зөв үү, буруу юу? Хувьцаа нэгтгэх тал дээр эсрэг байр суурьтай байна.

Б.Аюуш /Зөвлөх/- Хувьцаа нэгтгэх шалтгаан бол үл хөдлөх хөрөнгө худалдах нь гарцаагүй болсон. УБ-т ноос угаах үйлдвэр явуулахыг хориглосон. Тэгэхээр УБ хотод үйл ажиллагаа явуулахгүй болсноос хөдөө орон нутагт шилжүүлэхээс өөр гарц байхгүй. Үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах нь энэ компанийн ТУЗ, Гүйцэтгэх удирдлагаас үл хамаарсан шийдвэр гарсан. Үл хөдлөх хөрөнгөө худалдан борлогдох талаар ГЗахирал тайлбар өгөх байх. Хувьцаа нэгтгэх үйл ажиллагаа СЗХорооны шаардлагаар хийгдэж байгаа. Үл хөдлөх хөрөнгөө худалдаад орон нутагт үйл ажиллагааг шилжүүлнэ гэсэн байр суурьтай байгаа. СЗХороо жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдаж ав гэсэн шаардлага тавигдсан. Хувьцааг худалдаж авах эрхзүйн үндэс бол 2 тохиолдолд үүснэ. 1-т ХХК болох, 2-т Хувьцаа нэгтгэх. Тийм учраас ТУЗөвлөл ХХК болохыг зохистой биш гэж үзсэн. 100-аад жилийн түүхтэй компани хөрөнгийн зах зээл сэргэж байгаа, УБ-т ноос угаах үйлдвэр явуулахгүй нь ойлгомжтой, ноос ноолуурын чиглэлээр Монгол улсын нэрийг дэлхийд гаргах үндсэн чиглэл учраас ноосны чиглэлээр цаашид үйл ажиллагаа явуулна. Тэгэхээр ХХК болохгүй гэсэн байр суурьтай байгаа учраас хувьцаа нэгтгэх аргам замыг сонгосон. Жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааг шударга үнэнээр худалдаж авах эрхзүйн үндэслэл бий болж байна. Хувьцаа нэгтгэхийн эсрэг байр суурьтай болно. Үл хөдлөх хөрөнгийг худалдах хэлцэл хэдэн төгрөгөөр хийгдэж байгаа вэ?

Х.Эрдэнэбаяр/ГЗ/- ХЭХурлын шийдвэрээр үл хөдлөх хөрөнгө худалдах доод үнийг 35 тэрбум. төгрөгөөр тогтоосон байгаа. Худалдах хэлцэл явагдаж байгаа.

Б.Аюуш /зөвлөх/- Үл хөдлөх хөрөнгөө худалдана, өр төлбөрөө барагдуулна, үлдсэн хөрөнгөөрөө 2 аймагт үйлдвэр барьж байгуулна, 2 аймагт 2 угаах шугамыг суурилуулах ажил явагдана. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хийж байгаа. Хийж дуусаагүй учраас танилцуулаагүй байгаа байх. Хувьцаа эзэмшигчдийн эргүүлэн худалдаж авах тооцоог СЗХорооноос ТУЗ ХЭХурал хуралдуулах шийдвэр гаргаснаас хойш 4 хоногийн дараа бүртгэх өдрийг тогтоодог журам бараг 20 жилийн турш явж ирснийг СЗХороо хурал хуралдахаас 15 хоногийн өмнө гээд өөрчилсөн. Тэгэхээр 15 хоногийн өмнө эдгээр тооцоонуудыг хийх үндэслэл болсон Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хүлээж авсан гэсэн үг. Тэгэхээр 15 хоногийн өмнө энэ материалыг хүлээж аваад, та нарт өгөх материал бэлэн болсон гэсэн үг. Хувьцаа нэгтгэх асуудал бол ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зүгээс хийгдэж байгаа асуудал биш, СЗХорооны шаардлагаар хийгдэж байгаа ажил.

А.Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- СЗХороо нь санхүүгийн байгууллагад шийдвэр өгдөг байгууллага биш хяналтын байгууллага. СЗХорооны шийдвэр нь өмнөх ХЭХурлын шийдвэр хүчин төгөлдөр бус байна. Яагаад гэвэл энэ нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хөндөж байна. Хурлын шийдвэрийг зөвшөөрөхгүй гэсэн болохоос хувьцаагаа нэгтгэ, нэгтгэхгүй бол болохгүй гэсэн шаардлага өгдөг байгууллага биш. СЗХороо хууль, дүрмийн дагуу явуулахыг шаарддаг байгууллага биш аливаа нэг компанийн үйл ажиллагаанд ороод, хувьцаагаа нэгтгэх гм компанийн дотоод үйл ажиллагаанд ордоггүй.

Б.Аюуш /Зөвлөх/- Тийм биш. Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хөндөгдөж байгаа учраас та нар хувьцааг шударга үнээр худалдаж аваа гэсэн. Өмнөх ХЭХурал хүчин төгөлдөр болсон, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хөндөгдөж байна.

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

М.Амаржаргал /Хувьцаа эзэмшигч/- Надад асуулт байна, энд хамаагүй асуулт байж магадгүй. Би тэр 2 үйлдвэр хэзээ баригдахыг мэдэхгүй л байна. 35 тэрбум төгрөгөөр зарагдлаа гэхэд өр төлбөрөө барагдуулаад үлдсэн мөнгөөс хувьцаа эзэмшигчид эзэмших эрх байх уу?

Б.Аюуш /Зөвлөх/-Хэдэн ширхэг хувьцаатай вэ?

М.Амаржаргал /Хувьцаа эзэмшигч/- 7824ш хувьцаатай. Энэ үйлдвэр барих төсөл болохгүй, удвал бол компаниас хувьцаагаа аваад өөр юунд хийж болох уу?

Б.Аюуш /Зөвлөх/-Болно. Их хэмжээний хэлцэл хийж байгаа учраас хувьцаа эзэмшигч компанид хувьцаагаа 2827төгрөгөөр эргүүлэн худалдах эрх үүсч байгаа. Худалдсан хөрөнгөнөөс авах боломжгүй.

М.Гөлгөө /Хувьцаа эзэмшигч/- 50ш –ээс дээш хувьцаатай эзэмшигч байсан болох уу?

Б.Аюуш /Зөвлөх/-Болно.

Амаржаргал /Хувьцаа эзэмшигч/- Тэгвэл компани ажиллаж байсан нь бидэнд ашигтай. ХХК болох нь зүгээр байсан биш үү.

Гантуяа ХХК/Хувьцаа эзэмшигч/- ХЭХурал зохион байгуулж байгаа комисс дутуу ажилласан байна. Хувьцаа эзэмшигчид хурлын зар хүргэх журмын дагуу олон нийтэд зарласны дараа 5 хоног дотор брокерын пүүст хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гаргах шийдвэрийн төслийг хүргүүлэх журмыг зөрчөөд байна. Манай брокерын пүүст хурлын зар хугацаа хоцорч ирсэн.

Ж.Энхтунгалаг/Хувьцаа эзэмшигч/- ХЭХурлын зарыг Хөрөнгийн биржийн сайтнаас авч ирсэн.

Л.Нямжав/Хувьцаа эзэмшигч/- ХЭХурлын зарыг брокерын пүүст хугацаанд хүргүүлэх журамтай. Энэ талд хурал зохион байгуулах комисст шүүмжлэлтэй хандаж байна. Цаашдаа анхаарч ажиллана биз. Компани нь олон жил үйл ажиллагаа явуулаагүй, ногдол ашиг ч өгдөггүй, өр ширэнд баригдсан байгаа учраас компанийн хөрөнгөө хөдөлгөж, үйл ажиллагааг сэргээх талаар ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын авч байгаа арга хэмжээ авч байгаа нь зөв. Хувьцааг нэгтгэх асуудлыг дэмжиж байна.

М.Гөлгөө /Хувьцаа эзэмшигч/- Хувьцааг нэгтгэх асуудлыг дэмжиж байна.

М.Амаржаргал /Хувьцаа эзэмшигч/- Компанийн үйл ажиллагааг сэргээх гарц шийдэл нь зөв байна. Бизнес төлөвлөгөөтэй танилцвал шийдвэр гаргахад амар байна.

Х.Эрдэнбаяр /ГЗ/- Бизнес төлөвлөгөө хаана юунд зарцуулах нь төслийн хэмжээнд байгаа учраас танилцуулж болохгүй байна. ТУЗ-өөс зөвшөөрөл аваагүй учраас танилцуулж болохгүй байна.

4. **Хурлаар хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулж, саналын дүнг гаргаж** Тооллогын комиссын дарга Э.Тогосмаа Хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

Э.Тогосмаа/ ТКДарга/- Хуралд нийт 293599 саналын эрхтэй оролцогч оролцсноос Хувьцааг нэгтгэх асуудлыг 239172 санал буюу 81,4%, Хувьцааг нэгтгэх журам төслийг 239114 санал буюу 81,4%, Хувьцааг нэгтгэх өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулах асуудлыг 239114 санал буюу 81,4%-аар тус тус дэмжив.

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

ХЭХурлаас шийдвэрлэсэн нь:

1. Монноос ХК-ийн Хувьцааг нэгтгэх асуудлыг дэмжив.
2. Монноос ХК-ийн Хувьцааг нэгтгэх журмыг дэмжив.
3. Монноос ХК-ийн Хувьцааг нэгтгэх өөрчлөлтийг Компанийн дүрэмд оруулахыг дэмжив.

Тэмдэглэл бичсэн: Хурлын нарийн бичгийн дарга

Зөвшөөрсөн: Хурлын дарга



М.Тунгалаг

Б. Цолмон